



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон, нийт 141,779,000.00 (нэг зуун дөчин нэгэн сая долоон зуун далан есөн мянган) төгрөгийн балансын үнэ, 134,853,546.17 (нэг зуун гучин дөрвөн сая найман зуун тавин гурван мянга таван зуун дөчин зургаан төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Магнайсүрэн, Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч К.Болат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, ашиглаж болох материалыг ялган тоолж эргэлтийн хөрөнгөд бүртгэх, сэлбэг, материалаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Конторын барилгыг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд төрийн байгууллага /албан контор/-ын зориулалтаар нь ашиглах, байгууллагын газрыг нөхөн сэргээх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001545

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 04 дугаар сарын 02 ны өдрийн
 79 дугаар тогтоолын хавсралт

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо шир хэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Конторын барилга	1961.01.01	м.кв	250	138,510,000.00	131,584,546.17	6,925,453.83
2	Компьютер Acer	2014.06.30	ш	1	879,000.00	879,000.00	0.00
3	Компьютер Acer	2011.11.30	ш	1	850,000.00	850,000.00	0.00
4	Видео камер	2012.07.06	ш	1	1,340,000.00	1,340,000.00	0.00
5	Сандал	2013.06.17	ш	1	120,000.00	120,000.00	0.00
6	Лазер үзэг	2011.05.01	ш	1	80,000.00	80,000.00	0.00
	Дүн				141,779,000.00 (нэг зуун дөчин нэгэн сая долоон зуун далан есөн мянган)	134,853,546.17 (нэг зуун гучин дөрвөн сая найман зуун тавин гурван мянга таван зуун дөчин зургаан төгрөг арван долоон мөнгө)	6,925,453.83 (зургаан сая есөн зуун хорин таван мянга дөрвөн зуун тавин гурван төгрөг наян гурван мөнгө)